

# Жангжиажие Тэнгэрийн хаалга

| | | | |
|---|---|---|---|
| | **Жангжиажие** | УБ-Эрээн хот-Хөххот- Чанша-Жангжиажие-Хөххот -Эрээн-УБ | **2026.mm.dd-2026.mm.dd**<br>**9** шөнө **10** өдөр |

## Аяллын онцлох газар:

Аяллынхаа тойм зургийг харцгаая!

## Аяллын төлбөр:

УБ хотоос эхлэх үнэ: **2680.000₮**

Эрээн хотоос эхлэх үнэ: **2510.000₮**



**Жангжиажие хот. Тэнгэрийн хаалга**



**Жангжиажие хот. Гранд каньон шилэн гүүр**



**Жангжиажие хот. Тэнгэрийн хаалга**



**Фэнхуан тосгон. Эртний соёлт хот**



**Жангжиажие хот. Шар лууны агуй**



**Фуронг хот. Гайхалтай эртний хот**

90070022, 72233885






# Жанжиажие Тэнгэрийн хаалга

### 1 дэхь өдөр /УБ-Замын Үүд/

- Аялагчид маань энэ өдөр 15:30т УБТЗ дээр цуглана.
- 16:40 УБ-Замын үүд чиглэлийн галт тэрэгээр хөдөлнө.
- Энэ өдөр галт тэрэгэнд хононо.

Хоол ороогүй



### 2 дэхь өдөр /Замын үүд-Эрээн/

- Аялагчид маань энэ өглөө 07:30т галт тэрэгнээс буугаад хил гарах автобусандаа суун хил гаалиар нэвтэрнэ.
- Хилийн ачаалал зэргээс шалтгаалан удааширалтай байж болзошгүй тул аялагчид хүлээцтэй хандана уу.
- Хилээр нэвтрээд өдрийн хоолондоо орцгооно.
- Хоолоо идэсний зочид буудалдаа амарцгаана.

Өдрийн хоол





**90070022, 72233885**






# Жангжиажие Тэнгэрийн хаалга

## 3 дахь өдөр /Эрээн-Хөх хот-Чанша/

- Өглөө эрт цуглаж автобусандаа суун Эрээн хотын онгоцны буудал руу явцгаана.
- Эрээнээс Хөх хот руу нисэж хүрнэ. Хөх хотод ирсний дараа хэсэг хугацааны чөлөөт цагтай.
- Товлосон цагтаа цуглан Хөх хотоос Чангша хот руу нисэцгээнэ.
- Оройдоо бид Чанша хотод ирж зочид буудалдаа хүргүүлэн амарцгаана.

Оройн хоол



## 4 дахь өдөр /Чанша-Жангжиажие/

- Өглөө цайндаа орохдоо ачаа тээшээ авч гарна уу. Бид энэ өдөр өөр хот руу явцгаана.
- Өглөө товлосон цагтаа өглөөний цайгаа уугаад Жангжиажие хот руу хөдөлцгөөнө.
- Шаошань, Мао Зэдун агуу хүний төрсөн хотоор зочилно.
- Шар лууны агуйгаар аялна.
- Жанжиажэ Мөнхийн Хайр Гранд Театрт тоглолт үзэцгээнэ. /Зарим тохиолдолд тоглолт цуцлагдсан байдгийг ойлгоно уу. /
- Зочид буудалдаа амарцгаана.

Өглөөний цай, өдөр, оройн хоол





**90070022, 72233885**






# Жанжиажие Тэнгэрийн хаалга

## 5 дахь өдөр /Жанжиажие/

- Жанжиажие ойн цэцэрлэгт хүрээлэнгээр зугаална. Байлонг цахилгаан шат + Тианзи уулын кабель зам + VIP ногоон байгаль орчныг хамгаалах автобус багтсан.
- Жанжиажэ Гранд Каньоны шилэн гүүр

Өглөөний цай, Оройн хоол





## 6 дахь өдөр /Жанжиажие-Фуронг хот/

- Өглөөний цайгаа уусны дараа Тэнгэрийн хаалга руу явцгаана. Хугацаа:4 цаг орчим
- Фуронг хот бол Хятадын 3000 жилийн түүхтэй, өнөөг хүртэл цэцэглэн хөгжиж ирсэн цорын ганц эртний хот юм.

Өглөөний цай, өдрийн хоол





**90070022, 72233885**






# Жанжиажие Тэнгэрийн хаалга

## 7 дахь өдөр /Фэнхуан-Чанша/

- Өглөө нь Шинэ Зеландын алдарт зохиолч Реви Аллигийн Хятадын хамгийн үзэсгэлэнтэй жижиг хот гэж магтсан Фэнхуан эртний хотод зочилно. Хугацаа:4 цаг орчим





Өглөөний цай, өдрийн хоол



## 8 дахь өдөр /Чанша-Хөх хот/

- Энэ өдрийн өглөө бид өглөөний цайгаа уугаад товлосон цаг хүртэл чөлөөт цагтай.
- Чанша хотын онгоцны буудал руу явцгаан Хөх хот руу нисно.
- Хөх хотод ирэн транзит зочид буудалдаа очиж амарцгаана.

Өглөөний цай





90070022, 72233885





# Жангжиажие Тэнгэрийн хаалга

## 9 дахь өдөр /Хөх хот-Эрээн-Замын үүд/

- Энэ өдрийн өглөө эрт босоцгоон Эрээн хот руу нисэх онгоцондоо суусгааж Эрээн хотод ирнэ.
- Эрээн хотод ирэн 14 цаг хүртэл чөлөөт худалдааны цагийг өнгөрүүлээд хилээр гаргах автобусандаа суусгаан Замын үүд рүү явцгаана.
- Замын үүдэд ирэн галт тэрэгэндээ суусгаан Улаанбаатар хот руугаа явцгаана..



Хоол ороогүй

## 10 дахь өдөр /Улаанбаатар хот /

- Энэ өдрийн өглөө бид 09:20 цагт УБТЗ-д ирснээр бидний гайхалтай дурсамжтай энэхүү аялал маань өндөрлөнө.



**90070022, 72233885**





# Жанжиажие Тэнгэрийн хаалга

**Яагаад Жанжиажие гэж үү?**

Тианмэнь уул нь Жанжиажие хотоос ердөө 8 километрийн зайд оршдог. Тианмэнь агуй нь уулыг нэвтлэн ордог байгалийн карст агуй бөгөөд нутгийн иргэд үүнийг диваажинд хүрэх шууд зам гэж үздэг. Эртний хотын хүрхрээ нь Фуронг хотын байгалийн гайхамшиг бөгөөд тус хотод зочилж буй хүн бүрийн заавал үзэх ёстой газар юм. Гурван талаараа усаар хүрээлэгдсэн энэхүү хүрхрээ нь тус хотын дундуур урсаж, өвөрмөц, сэтгэл татам дүр зургийг бий болгодог. Энэ бол баруун Хунань мужийн хамгийн том бөгөөд хамгийн гайхалтай хүрхрээ бөгөөд 60 метр өндөр, 40 метр өргөн бөгөөд хадан цохионоос хоёр үе шаттайгаар урсаж, асар их хүчээр, хэдэн милийн зайд сонсогддог. Хавар, зуны улиралд усны түвшин нэмэгдэхэд голын урсгал доошоо шумбаж, солонго, гайхалтай өнгө төрхийг бий болгодог. Тус хотын нэрийг энэхүү хүрхрээнээс авсан бөгөөд үүнийг "хүрхрээн дээр өлгөөтэй эртний хот" гэж дүрсэлдэг. Үүнийг магтан дуулсан шүлэгт: "Аянга мэт архиралт дэлхийг доргиож, тэнгэрээс мянган овоолсон цас унаж, асар том Сүүн зам тэнгэрээс бууж, тоо томшгүй олон сувд хаа сайгүй нисдэг" гэжээ.

**Фуронг хот**

Эртний хотын хүрхрээ нь Фуронг хотын байгалийн гайхамшиг бөгөөд тус хотод зочилж буй хүн бүрийн заавал үзэх ёстой газар юм. Гурван талаараа усаар хүрээлэгдсэн энэхүү хүрхрээ нь тус хотын дундуур урсаж, өвөрмөц, сэтгэл татам дүр зургийг бий болгодог. Энэ бол баруун Хунань мужийн хамгийн том бөгөөд хамгийн гайхалтай хүрхрээ бөгөөд 60 метр өндөр, 40 метр өргөн бөгөөд хадан цохионоос хоёр үе шаттайгаар урсаж, асар их хүчээр, хэдэн милийн зайд сонсогддог. Хавар, зуны улиралд усны түвшин нэмэгдэхэд голын урсгал доошоо шумбаж, солонго, гайхалтай өнгө төрхийг бий болгодог. Тус хотын нэрийг энэхүү хүрхрээнээс авсан бөгөөд үүнийг "хүрхрээн дээр өлгөөтэй эртний хот" гэж дүрсэлдэг. Үүнийг магтан дуулсан шүлэгт: "Аянга мэт архиралт дэлхийг доргиож, тэнгэрээс мянган овоолсон цас унаж, асар том Сүүн зам тэнгэрээс бууж, тоо томшгүй олон сувд хаа сайгүй нисдэг" гэжээ.

90070022, 72233885




# Жанжиажие Тэнгэрийн хаалга

## Аяллын төлбөрт багтсан:

- Улаанбаатар-Замын Үүд- Улаанбаатар галт тэрэгний билет
- Эрээн-Хөххот-Чанша 2 талын онгоцны тийз
- Хил гаалиар нэвтрэх автобусны зардал
- Хот хоорондын аялал жуучлалын автобус
- Хөтөлбөрт багтсан үзвэр үйлчилгээ: Шар лууны агуй, Мөнхийн хайрын театр, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Байлонг цахилгаан шатны дээд буудал, Гранд хавцал гүүр, Тэнгэрийн хаалганы кабель кар, Тэнгэрийн хаалганы баруун шилэн гүүр, урсдаг шат, Фуронг хотын цогцолбор хүрээлэн, Фэнхуан эртний соёлтой тосгоноор аялах.
- Хөтөлбөрт заасан хоол-  5 өглөөний цай, 7 өдөр/оройн хоол
- ОУ-н стандарт тав тухтай Зочид буудал- 7шөнө
- Аяллын даатгал

## Аяллын төлбөрт багтаагүй:

- Хувь хүний хэрэглээний зардал
- Хөтөлбөрт заагдсанаас бусад үзвэр үйлчилгээ
- Нэг хүний өрөөнд 2 хүн орохоор тооцсон ба ганцаараа орохыг хүсэх болон нэмэгдэж орох бол нэмэлт төлбөр тооцохыг анхаарна уу.
- Зорчигчийн гэрээ зөрчсөн, хувийн буруутай үйл ажиллагаа явуулсан, эсвэл бие махбодид гэмтэл учруулсан, эд хөрөнгийн хохирол учруулсан өвчний улмаас гарсан нэмэлт зардал;
- Гэнэтийн хүчин зүйлийн улмаас гарсан зардал, үүнд урьдчилан тооцоологүй, зайлшгүй, даван туулах боломжгүй бодит нөхцөл байдлаас үүдэлтэй зардал орно;
- Төлбөрт багтсан зүйлд дурдаагүй бусад зүйлс.

90070022, 72233885




# Жангжиажие Тэнгэрийн хаалга

| | |
|---|---|
| 1. | Аяллын үед гадаад паспортны хүчинтэй байх хугацаа 6 сараас доошгүй байх. |
| 2. | Хэрэв та хамаатан садан төрлийн 18 нас хүрээгүй хүүхдийг авч явах бол садан төрлийн лавлагаа, эцэг эхийн зөвшөөрлийн хамт нотариатаар баталгаажуулан авч явах. |
| 3. | Өөрийн 18 нас хүрээгүй хүүхдийг авч явах бол төрсөний гэрчилгээг авч явна. |
| 4. | Хэрэв танд тусгай хэрэгцээ байдаг бол бидэнд зайлшгүй урьдчилан мэдэгдэх шаардлагатай. |
| 5. | Аяллын туршид согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх, бусдад төвөг чирэгдэл учруулахгүй байх. |
| 6 | Аяллын багаас ганцаараа болон бүлгээрээ дур мэдэн салж явахгүй байх, аяллын тогтсон цаг хугацаа хуваарийг чандлан сахиж бусад аялагчидаа хүндэтгэн аялалдаа оролцох. |
| 7. | Тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журмыг чандлан сахиж зөрчихгүй аялах, улсынхаа нэр төрийг эрхэмлэн ёс зүйг эрхэмлэн аялана уу! |
| 8. | Хувийн хэрэглээний зүйлс, хэрэглэдэг эм бэлдмэлээ бэлтгэн авч явах. |

90070022, 72233885



# Жанжиажие Тэнгэрийн хаалга

| | |
|---|---|
| 9. | Тухайн аялаж буй улс орныхоо тухай ёс заншил, шашин шүтлэг, амьдралын хэв маяг зэргийг урьдчилан судлан мэдэж авч хүндэтгэлтэй хандана уу. |
| 10. | Аялаж буй газрынхаа нөхцөл байдал, цаг агаар, газар зүйн байршил, цагийн зөрүү, ёс заншилд тохируулан хувийн бэлтгэлээ хангаж, идэж хэвшсэн өөрт тохирсон хоол хүнсээ базаах зэргээр хувийн аюулгүй байдалд анхааран аялна уу. |
| 11. | Байгаль, цаг уурын нөхцөл, техникийн саатал, гэнэтийн хүндэтгэх нөхцөл шалтгааны улмаас аяллын хөтөлбөрт өөрчлөлт орж болзошгүй, мөн валютын ханшны өөрчлөлт, хил гаалийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан төлбөрт өөрчлөлт орж болзошгүй зэргий ойлгон хүлээцтэй хандана уу. |
| 12. | Аялалд явах хугацаандаа гэр бүл, ажлын зохицуулалтыг бүрэн хийсэн байх бөгөөд үүнтэй холбоотой аливаа асуудалд аялал зохион байгуулагчид хариуцлага хүлээхгүй. |
| 13. | Хэрэв аяллын бүлэгээс салж явах, хувийн шугамаар найз нөхөд түншүүдтэйгээ уулзахаар явах бол хөтөчид заавал мэдэгдэх. |
| 14. | Хэрэв ямар нэгэн асуудал үүссэн тохиолдолд тухай бүрт нь аялал зохион байгуулагч, хөтөчид хэлэн шийдвэрлүүлэх боломжтой тул та шууд хандах хэрэгтэй. |
| 15. | Дээрх зөвлөмжүүдийг сайтар уншиж танилцах шаардлагатай бөгөөд тус анхааруулгыг дагаж мөрдөөгүйгээс үүсэх аливаа асуудалд аялал зохион байгуулагчид хариуцлага хүлээхгүй болно. |



90070022, 72233885





# Жанжиажие Тэнгэрийн хаалга

## Аяллын үеийн нөхөрсөг зөвлөмж

Та холын замд аялахдаа өөрийн хэрэглэх эм бэлдмэл, хувийн хэрэглээний зүйлс, ус ундааны сав зэргийг ойрхон авч яваарай!

Тухайн улсын хоол хүнсийг идэж чадахгүй бол өөрийн хэрэглэж хэвшсэн хүнсийг базааж яваарай!

Аяллын туршид өөрийн бичиг баримт, үнэт эдлэл, эд зүйлсдээ эзэн байж алдаж гээхээс болгоомжилно уу. Хил гаалиар нэвтрэх үед зөвхөн өөрийн ачаа тээшийг хариуцаж яваарай!

Зочид буудалаас гадуур гарахдаа зочид буудлын хаягийг мэдэж авах, зочид буудлын нэрийн хуудас зэргийг авч гараарай. Нутгийн иргэдтэй найрсаг харьцаж муудаж маргалдахгүй аялаарай!

Таны аялалд амжилт хүсэж, Мартагдашгүй дурсамж бүтээн зорьсон бүхнээ биелүүлэх ерөөл өргөе!

Манайхыг сонгосон та бүхэнд маш их баярлалаа.

**Тэнгэрээр газраар, Тэнгис далайгаар**

**ТРЭНД АЯЛАЛ**

**90070022, 72233885**